



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ  
ХУРАЛДААНД БЭЛТГЭХ АЖЛЫН  
ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.11, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.“Давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг давж заалдах шатны шүүхүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Улсын дээд шүүхийн Тамгын газар /С.Заяадэлгэр/-т даалгасугай.

3.Журмыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн давж заалдах шатны шүүхүүд дагаж мөрдсүгэй.

4.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.25-д заасан хэргийн хөдөлгөөний удирдлагын хүрээнд энэ журмын хэрэгжилтэд Шүүхийн ерөнхий зөвлөл дүн шинжилгээ хийж ажиллахыг зөвлөсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ


Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн  
хуралдааны 2023 оны 12 сарын 28-ны  
өдрийн 44 дүгээр тогтоолын хавсралт

**ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНД  
БЭЛТГЭХ АЖЛЫН ЖУРАМ**



**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмаар давж заалдах шатны шүүх хуралдаанд хэргийг хэлэлцүүлэхэд бэлтгэх ажил, түүний хугацаа, дарааллыг тогтоох, шүүх хуралдаанд бэлтгэх чиг үүргийн хуваарилалтыг тодорхойлох шүүхийн дотоод ажлын зохион байгуулалттай холбогдох харилцааг зохицуулна.

1.2. Монгол Улсын Үндсэн хуульд заасан “шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх” -ийг бүрэн, бодитоор хэрэгжүүлэх нөхцөлийг хангах, шүүн таслах ажиллагааны чанарыг шалгуур болгон “бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хэлэлцэн шийдвэрлэх” зохицуулалтыг<sup>1</sup> Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалаар хэрэгжүүлэхэд энэ журмын зорилго оршино.

1.3. Энэ журмыг Монгол Улсын шүүхийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн хэрэглэнэ.

**Хоёр. Шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, дараалал**

2.1. Давж заалдах шатны шүүх хуралдааны бэлтгэл ажлын бүрдэлд хэргийг хүлээн авсан шүүгч (цаашид *Шүүгч* гэнэ) -ийн туслах хэргийн бүрдлийн баримт хөтлөх, шүүх бүрэлдэхүүн хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг тодорхойлох, бэлтгэх ажиллагаа хамаарна.

2.2. Давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдлийг доорх дараалал, хугацааны дагуу гүйцэтгэнэ:

Д/д	Бэлтгэх ажлын бүрдэл	Гүйцэтгэх хугацаа
1	Шүүх хэрэг хүлээн авч хуваарилах, шүүгчид хүлээлгэн өгөх;	Тухайн өдрөө (нэн даруй)

<sup>1</sup> Монгол Улсын үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 1-д “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ”.

2	Сугалаагаар шүүх бүрэлдэхүүнийг томилох;	Хэрэг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор, хуульд зааснаар өөр шүүхээс бүрэлдэхүүн томилогдох тохиолдолд шаардагдах хугацаанд
3	Шүүгчийн туслах давж заалдах гомдол, эсэргүүцлийг хэргийн хамт холбогдох журмын дагуу хүлээн авсны дараа хэргийн бүрдлийг баримтын <sup>2</sup> дагуу шалган тэмдэглэж, шүүгчид хүлээлгэн өгөх;	Хэрэг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор
4	Хэргийг хүлээн авсан шүүгч хавтаст хэрэгтэй урьдчилан танилцаж, тухайн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэхийн тулд шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг тодорхойлох;	Шүүгч хэрэг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор, олон хавтастай хэргийн хувьд шаардагдах хугацаанд
5	Шүүх бүрэлдэхүүн хавтаст хэрэг болон шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалттай танилцах;	Нэг шүүгч 3 хоногийн дотор, олон хавтастай хэргийн хувьд шаардагдах хугацаанд
6	Бэлтгэх ажиллагааг дүгнэж, шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг батлах;	Шүүгч хэрэг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор
7	Шүүгч хэргийн оролцогчдын саналыг харгалзан хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан болох өдрийг эцэслэн товлох	Шүүгч хэрэг хүлээн авснаас 20 хоногийн дотор

2.3. Хэлэлцвэл зохих асуудлын жагсаалт<sup>3</sup> нь давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянан үзэх чиг үүргээ үр дүнтэйгээр хэрэгжүүлэх шаардлагад үндэслэн давж заалдах шатны шүүхийн хяналтын хүрээг тодорхойлоход чиглэнэ.

<sup>2</sup> “Эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн бүрдлийн баримт”-ын загварыг энэ журмын 1 дүгээр хавсралтын А, Б, В-р батлав.

<sup>3</sup> “Шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтын баримт”-ын загварыг энэ журмын 2 дугаар хавсралтаар батлав.

2.4.Шүүгч гомдол, эсэргүүцэл, тэдгээрт дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий эсэхийг тогтооход ач холбогдол бүхий хэлэлцвэл зохих асуудлыг бүрэн тодорхойлоход анхаарна.

2.5.Шүүгч хэлэлцвэл зохих асуудлыг тодорхойлохдоо хэргийн шийдэл, давж заалдах гомдол үндэслэлтэй эсэх талаар урьдчилсан дүгнэлт хийхгүй.

2.6.Үүнд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тодруулах шаардлагатай үйл баримт болон хууль зүйн тайлбар, хэрэглээний аливаа асуудлыг тодорхойлох, хэргийг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай гол агуулгын жагсаалтыг томъёолоход анхаарна.

2.7.Шүүгч жагсаалтыг боловсруулахдаа шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий эсэхийг тогтоох шаардлагад үндэслэн хэлэлцвэл зохих асуудлыг дараах байдлаар төрөлжүүлэн тодорхойлбол зохино:

2.7.1.Шүүх хэрэг маргааныг хуульд заасан журмын (процессын асуудал) дагуу хянан шийдвэрлэсэн эсэхийг тодруулахтай холбоотой;

2.7.2.Шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай үйл баримтыг зохих ёсоор тогтоосон эсэх, баримтыг бүрэн үнэлсэн эсэхийг тодруулахтай холбоотой;

2.7.3.Хэрэглэх хууль, өрсөлдөөнт хэм хэмжээг сонгохтой холбоотой;

2.7.4.Шүүх хуулийг зөв хэрэглэж хэрэг маргааныг шийдвэрлэсэн эсэх, хуулийн албан ёсны тайлбар, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахтай холбоотой;

2.7.5.Хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хэрэглэгдэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй, харшилсан гэж үзэх үндэслэл байгаа эсэх:

2.8.Шүүгчийн туслах давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, дарааллын талаар баримт<sup>4</sup> хөтөлнө.

### **Гурав. Бэлтгэх ажиллагаа**

3.1.Бэлтгэх ажиллагаа нь хэргийг хамтын зарчмаар давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэх үед зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудлын жагсаалт, цар хүрээг тогтооход чиглэнэ.

3.2.Бэлтгэх ажиллагаа нь шүүхийн дотоод ажлын зохион байгуулалтын нэг төрөл байна.

---

<sup>4</sup> Энэ журмын 3 дугаар хавсралт. Энэ баримтыг “хэргийн хөдөлгөөний баримт”-ын хувьд архивын нэгж болгон хадгална.

3.3.Шүүх бүрэлдэхүүн бэлтгэх ажиллагааг дүгнэж, хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг батлахын өмнө энэ журмын 2.7-д заасан жагсаалт, хавтас хэрэгтэй танилцсан байна.

3.4.Шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсны улмаас адил шатны өөр шүүхийн шүүгчийг шүүх бүрэлдэхүүнд томилох болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас биечлэн оролцох боломжгүй тохиолдолд бэлтгэх ажиллагааг цахимаар зохион байгуулж болно.

3.5.Шүүх бүрэлдэхүүн илтгэгч шүүгчийн боловсруулсан шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг ярилцан тодорхойлох, нэмж өөрчлөх саналыг хэлэлцэнэ. Түүнчлэн, хэргийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэхэд шаардлагатай хууль, эрх зүйн болон ижил төстэй хэргийн судалгаа гэх мэт бусад бэлтгэл ажлыг хангахад чиглэсэн асуудлуудыг хэлэлцэн шийднэ.

3.6.Бэлтгэх ажиллагаа нь энэ журмын 2 дугаар зүйлийн 2.5 дах хэсэгт заасан шаардлагын дагуу хэргийн шийдэл, давж заалдах гомдол үндэслэлтэй эсэх талаар урьдчилан хэлэлцэхгүй.

3.7.Бэлтгэх ажиллагаагаар тодорхойлсон шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэвэл зохих асуудлын цар хүрээ, жагсаалт нь хэргийн оролцогч хуульд заасан журмын дагуу нэмэлтээр гаргасан гомдол, тайлбарт дурдсан асуудлыг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд хязгаарлалт болохгүй.


3.8.Бэлтгэх ажиллагаанд шүүх бүрэлдэхүүн, илтгэгч шүүгчийн туслах оролцоно.

3.9.Бэлтгэх ажиллагааны зохион байгуулалтыг хангах ажлыг шүүгчийн туслах хариуцах ба тус ажиллагаанд тэмдэглэл хөтлөхгүй. Харин Бэлтгэх ажиллагаагаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтад өөрчлөлт орсон эсэх талаар энэ журмын 2.8-д заасан баримтад бичилт хийнэ.

3.10.Бэлтгэх ажиллагааны дараа шүүх хуралдаанаас өмнө илтгэгч шүүгчийн туслах шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалттай уялдуулан хянан хэлэлцэх хэрэгтэй төсөөтэй хэргийг судалж бэлтгэнэ.

---\*---

Давж заалдах шатны шүүх хуралдаанд  
бэлтгэх ажлын журмын 1 дүгээр хавсралт



**А. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн бүрдлийн баримт**

Анхан шатны шүүхийн нэр		
Шүүгдэгч, цагаатгагдсан этгээд		
Шийдвэрийн огноо, дугаар		
Шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн		
Гомдол гаргагч, гомдолд гарын үсэг зурагдсан эсэх		
Давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцэл огноо, хуулийн хугацаанд гаргасан эсэх		
Гомдлыг танилцуулсан эсэх		
Давж заалдах шатны шүүхэд хэрэг хүлээн авсан огноо, цаг, минут		
Гомдол, эсэргүүцэл хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэх		
<b>Нэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүрдэл</b>		
Д/д	Хийгдэх ажиллагаа	Тайлбар
1	Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах болон эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа хийгдэх ажиллагааг шалгах	
2	Прокурор мөрдөн шалгах ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх явцдаа гаргасан шийдвэрийг шалгах	
3	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд	

	оролцогчийн эрхийг хангасан байдлыг шалгах	
4	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчоос гаргасан хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдлыг шалгах	
5	Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагааг шалгах	
6	Шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагааг хянах	
<b>Хоёр. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүрдэл</b>		
7	Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шалгах	
8	Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байдлыг шалгах	
9	Гэрч, шинжээчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд журмын дагуу оролцуулсан, эсэх	
10	Шүүх бүрэлдэхүүн хуулийн дагуу томилогдсон эсэх, сольсон бол ШЗТогтоол (үндэслэл) байгаа эсэх	
11	Хуралдааны тэмдэглэл хөтлөлтийг хуулийн дагуу хөтөлсөн эсэх	
12	Хэргийн оролцогчдод хурлын товыг хуульд заасан хугацаанд мэдэгдэж, шүүх хуралдаанд оролцох эрхийг хангасан эсэх	
13	Хэрэгт авагдсан нотлох баримт хуулийн шаардлага хангасан эсэх	
14	Хэргийн оролцогчдод эрх үүргийг нь танилцуулж эдлүүлсэн эсэх	
15	Хэргийн оролцогчдод хавтаст хэрэг, материалыг танилцуулсан эсэх	
16	Бусад	

<b>Гурав. Давж заалдах гомдол, эсэргүүцэл дурдагдсан үндэслэлд харгалзуулан хянах</b>		
17	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн	
18	Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн	
19	Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй	
20	Бусад	



## Б. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн бүрдлийн баримт

Анхан шатны шүүхийн нэр			
Нэхэмжлэгч			
Хариуцагч			
Гуравдагч этгээд			
Шийдвэрийн огноо, дугаар			
Шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн			
Гомдол гаргагч, гомдолд гарын үсэг зурагдсан эсэх			
Давж заалдах журмаар гаргасан гомдлын огноо, хуулийн хугацаанд гаргасан эсэх			
Гомдлыг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлд уг эрхийг тусгайлан заасан эсэх			
Гомдлыг танилцуулсан эсэх			
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэх /Илүү эсвэл дутуу төлсөн эсэх/			
Давж заалдах шатны шүүхэд хэрэг хүлээн авсан огноо, цаг, минут			
Гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэх			
<b>Нэг. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүрдэл</b>			
Д/д	Хийгдэх ажиллагаа		Тайлбар
1	Итгэмжлэл	Нэхэмжлэгч	
		Хариуцагч	
		Гуравдагч этгээд	
2	Нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэсэн огноо		
	Нэхэмжлэлийг шийдвэрлэсэн огноо		
3	Шүүхийн болон хэргийн харьяаллын талаар маргаантай эсэх		
4	Нэхэмжлэлийн /сөрөг/ шаардлага, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн шаардлага, хариуцагч бүрд холбогдох		

	шаардлагыг бүрэн шийдвэрлэсэн эсэх	
5	Иргэн хуулийн этгээдийг гуравдагч этгээдээр татсан эсэх, бие даасан шаардлага гаргасан эсэх	
6	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан хүсэлт	Нэхэмжлэгч
		Хариуцагч
		Гуравдагч этгээд
7	Гэрч, шинжээчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд журмын дагуу оролцуулсан, эсэх	
8	Шүүх бүрэлдэхүүн хуулийн дагуу томилогдсон эсэх, сольсон бол ШЗТогтоол (үндэслэл) байгаа эсэх	
9	Хуралдааны тэмдэглэлийг хуулийн дагуу хөтөлсөн эсэх	
10	Хэргийн оролцогчдод хурлын товыг хуульд заасан хугацаанд мэдэгдэж, шүүх хуралдаанд оролцох эрхийг хангасан эсэх	
11	Хэрэгт авагдсан нотлох баримт хуулийн шаардлага хангасан эсэх	
12	Хэргийн оролцогчдод эрх үүргийг нь танилцуулсан эсэх	
13	Хэргийн оролцогчдод хавтаст хэрэг, материалыг танилцуулсан эсэх	
14	Бусад	
<b>Хоёр. Давж заалдах гомдолд дурдагдсан үндэслэлд харгалзуулан хянах</b>		
15	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдсөн	

16	Хууль буруу тайлбарлан хэрэглэсэн	
17	Нотлох баримтыг буруу үнэлсэн	
18	Бусад	

**В. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хэргийн бүрдлийн баримт**

Анхан шатны шүүхийн нэр			
Нэхэмжлэгч			
Хариуцагч			
Гуравдагч этгээд			
Шийдвэрийн огноо, дугаар			
Шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн			
Гомдол гаргагч, гомдолд гарын үсэг зурагдсан эсэх			
Давж заалдах журмаар гаргасан гомдлын огноо, хуулийн хугацаанд гаргасан эсэх			
Гомдлыг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлд уг эрхийг тусгайлан заасан эсэх			
Гомдлыг танилцуулсан эсэх			
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэх /Илүү эсвэл дутуу төлсөн эсэх/			
Давж заалдах шатны шүүхэд хэрэг хүлээн авсан огноо, цаг, минут			
Гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэх			
<b>Нэг. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүрдэл</b>			
Д/д	Хийгдэх ажиллагаа		Тайлбар
1	Итгэмжлэл	Нэхэмжлэгч	
		Хариуцагч	
		Гуравдагч этгээд	
2	Нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэсэн огноо		
	Нэхэмжлэлийг шийдвэрлэсэн огноо		
3	Шүүхийн болон хэргийн харьяаллын талаар маргаантай эсэх		
4	Нэхэмжлэлийн /сөрөг/ шаардлага, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн шаардлага,		

	хариуцагч бүрд холбогдох шаардлагыг бүрэн шийдвэрлэсэн эсэх	
5	Иргэн хуулийн этгээдийг гуравдагч этгээдээр татсан эсэх, бие даасан шаардлага гаргасан эсэх	
6	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан хүсэлт	Нэхэмжлэгч
		Хариуцагч
		Гуравдагч этгээд
7	Гэрч, шинжээчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд журмын дагуу оролцуулсан, эсэх	
8	Шүүх бүрэлдэхүүн хуулийн дагуу томилогдсон эсэх, сольсон бол ШЗТогтоол (үндэслэл) байгаа эсэх	
9	Хуралдааны тэмдэглэлийг хуулийн дагуу хөтөлсөн эсэх	
10	Хэргийн оролцогчдод хурлын товыг хуульд заасан хугацаанд мэдэгдэж, шүүх хуралдаанд оролцох эрхийг хангасан эсэх	
11	Хэрэгт авагдсан нотлох баримт хуулийн шаардлага хангасан эсэх	
12	Хэргийн оролцогчдод эрх үүргийг нь танилцуулсан эсэх	
13	Хэргийн оролцогчдод хавтаст хэрэг, материалыг танилцуулсан эсэх	
14	Урьдчилсан хэлэлцүүлэг хийсэн эсэх	
15	Бусад	
<b>Хоёр. Давж заалдах гомдолд дурдагдсан үндэслэлд харгалзуулан хянах</b>		
16	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдсөн	

17	Хууль буруу тайлбарлан хэрэглэсэн	
18	Нотлох баримтыг буруу үнэлсэн	
19	Бусад	

Давж заалдах шатны шүүх хуралдаанд  
бэлтгэх ажлын журмын 2 дугаар хавсралт

**Давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцвэл  
зохих асуудлын жагсаалт**

20 ... оны ... сарын ...-ны өдөр

№	Хэргийн мэдээлэл
1	Хэргийн индекс (Хэргийн дугаар)
2	Нэхэмжлэгч (Прокурор)-ийн нэр
3	Хариуцагчийн нэр (Шүүгдэгчийн нэр)
4	Нэхэмжлэлийн шаардлага (холбогдсон гэмт хэрэг, маргаан бүхий акт) ..... ..... .....
5	Нэхэмжлэл (яллах дүгнэлт, захиргааны акт)-д хэрэглэсэн хууль ..... ..... .....
6	Анхан шатны шүүхийн хэрэглэсэн хууль ..... ..... .....
7	Давж заалдах гомдлын (эсэргүүцэл) үндэслэл ..... ..... .....
<b>Давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудал</b>	
8	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын (процесс) дагуу явагдсан эсэхтэй холбоотой асуудал: ..... ..... .....

9	<p>Анхан шатны шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ үйл баримтыг зохих ёсоор тогтоож, нотлох баримтыг үнэн зөв эргэлзээгүй үнэлсэн эсэхтэй холбоотой асуудал:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
10	<p>Анхан шатны шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хуулийг зөв хэрэглэсэн (эрэмбэ, өрсөлдөөнт хэм хэмжээг сонгох, тайлбарлах арга зүй, хэрэглэгдэх хууль, олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй, харшилсан гэж үзэх үндэслэл байгаа эсэх) эсэхтэй холбоотой асуудал:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
11	<p>Давж заалдах шатны шүүхээс магадлах цар хүрээ, хэр хэмжээ (<i>Standard of review</i>):</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p><i>(Жишээ нь: -зөвхөн процесс, тухайлбал хууль бус бүрэлдэхүүн эсэхийг хянах гэх мэт)</i></p>
12	<p>Зайлшгүй хэлэлцэж шийдвэрлэх шаардлагатай бусад асуудал:</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p><b>Шүүн таслах ажиллагааны практикийг судалж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа Улсын дээд шүүхэд уламжлах шаардлагатай эсэх<sup>5</sup></b></p>	
<p><b>Тойм бичих саналтай эсэх</b></p>	

Шүүх бүрэлдэхүүн:.....


.....

.....

<sup>5</sup> Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5.4 дэх хэсэг



Давж заалдах шатны шүүх хуралдаанд  
бэлтгэх ажлын журмын 3 дугаар хавсралт



**Давж заалдах журмаар хэлэлцэх хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх ажлын дараалал**

Хэрэг шийдвэрлэх хугацааны мэдээлэл					
Нэхэмжлэгч, хариуцагчийн нэр				Шийдвэрийн огноо, дугаар	
Хэрэг хүлээн авсан огноо, цаг минут				Хуульд заасан 30 хоног дуусах өдөр /огноо/ .....	
Шүүх хуралдаанд бэлтгэх ажлын дараалал, хугацаа					
№	Хийх ажиллагаа	Хариуцах эзэн	Гүйцэтгэх хугацаа, огноо	Гүйцэтгэсэн хугацаа, огноо	Тайлбар
1	Шүүх хэрэг хүлээн авч хуваарилах, шүүгчид хүлээлгэн өгөх	Тамгын газрын ажилтан	Тухайн өдрөө /0/		
2	Сугалаагаар шүүх бүрэлдэхүүнийг томилох	Тамгын газар	Хэрэг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор		
3	Шүүгчийн туслах давж заалдах гомдол, эсэргүүцлийг хэргийн хамт холбогдох журмын дагуу хүлээн авсны дараа хэргийн бүрдлийг баримтын дагуу шалган тэмдэглэж, шүүгчид хүлээлгэн өгөх	Илтгэгч шүүгчийн туслах	Хэрэг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор		
4	Хэргийг хүлээн авсан шүүгч хавтаст хэрэгтэй урьдчилан танилцаж, тухайн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэхийн тулд шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг тодорхойлох	Илтгэгч шүүгч	Хэрэг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор		

5	Шүүх бүрэлдэхүүн хавтаст хэрэг болон шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалттай танилцах	Шүүх бүрэлдэхүүн	Хэрэг нэг шүүгчид 3 хоногийн дотор		
6	Бэлтгэх ажиллагааг хийж, шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг батлах	Илтгэгч шүүгч, шүүгчийн туслах, шүүх бүрэлдэхүүн	Хэрэг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор		
7	Шүүгч хэргийн оролцогчдын саналыг харгалзан хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан болох өдрийг эцэслэн товлох	Илтгэгч шүүгч	Хэрэг хүлээн авснаас 20 хоногийн дотор		

Баримтыг хөтөлсөн: Шүүгчийн туслах .....